



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,
Сэлэнгэ аймаг, 43081
Утас/Факс: (976)-7036-3040
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

「 БАРУУНБҮРЭН СУМЫН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ЭЭЛЖИТ
СОНГУУЛЬД ОРОЛЦОХ МОНГОЛ АРДЫН
НАМД

2024.08.06 № ТНАГ/2024/13-ИТАНА-03
танай _____-ны № _____-т

「 Сонгуулийн мөрийн хөтөлбөр хуульд
заасан шаардлагад нийцсэн талаарх дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.4-т заасан төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд 2024 оны Баруунбүрэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох Монгол Ардын намын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Баруунбүрэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцооны хамт ирүүлж, хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газар нь 2024 оны аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох нам, эвслийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817-1:2020 Тулгуур зарчим, Төрийн аудит MNS 6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, Төрийн аудит MNS 6817-8:2020 Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого,

018020597

УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хууль, холбогдох байгууллагаас авсан тайлан, судалгаа, мэдээллийг тус тус шалгуур болгон авч үзсэн.

Дүгнэлт

Монгол Ардын намын Баруунбүрэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрийн зорилт арга, хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Баруунбүрэн сумын Монгол Ардын намын мөрийн хөтөлбөр (04 хуудас)-ийг хавсаргав.

Хувийг: Баруунбүрэн сумын Сонгуулийн хороонд

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН БАРУУНБҮРЭН СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН 2024 ОНЫ ЭЭЛЖИТ СОНГУУЛЬД БАРУУНБҮРЭН СУМЫН МАН-ЫН
ХОРООНООС ДЭВШҮҮЛЖ БУЙ МӨРИЙН ХӨТӨЛБӨР**

2024.06.20

Бургалтай

Хамтын хүч-Сумын хөгжил

Монгол Ардын Намын 2024 оны УИХ-ын Сонгуулийн мөрийн хөтөлбөр, Сэлэнгэ аймгийн ИТХ-ын 2024 оны сонгуулийн мөрийн хөтөлбөрт үндэслэн иргэд, төрийн байгууллагаас ирүүлсэн саналуудыг нэгтгэн 2024–2028 онд Баруунбүрэн сумын хөгжлийн зорилтуудыг шийдвэрлэн хэрэгжүүлэх мөрийн хөтөлбөрөө өргөн танилцуулж байна.

Нэг. Эрүүл мэнд

1.1. Нийгмийн эрүүл мэндийн тогтолцоог ханган бэхжүүлэх зорилтын хүрээнд “Идэвхтэй–Эрүүл амьдрал” хөтөлбөрийг үргэлжлүүлэн дасгал хөдөлгөөн хийх, нийтийн бие тамираар хичээллэх, дугуйн спортыг хөгжүүлэх, цэнгээнт бүжгээр тогтмол хичээллэх, эрүүл зөв хооллолт, амьдралын хэв маяг, дадал зуршилд суралцах сургалт явуулах ажлыг тасралтгүй зохион байгуулна.

1.2. “Эрүүл шүд”, “Эрүүл хүүхэд” хөтөлбөрүүд болон “Эрт илрүүлэг”, Эрүүл мэндийн үзлэгт сумын хүн амыг тогтмол хамруулна.

1.3. Сумын ЭМТ-д ажиллах эмч, сувилагчдыг бүрэн орон тоогоор ажиллуулахад бодлогоор дэмжиж ажиллана.

1.4. Иргэд, хөдөөгийн хүн амд үзүүлэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээг шуурхай чирэгдэлгүй болгоход анхаарч, түргэн тусламжийн машины бэлэн байдлыг хангаж ажиллана.

1.5. ЭМТ-ийн морг, түргэн тусламжийн машины гражийг шинэчлэн засварлах, өргөтгөлийн барилгын халаалтын системийг засварлах ажлыг шат дараатайгаар хийнэ.

1.6. Эмийн сангийн зориулалтаар ашиглаж байсан байшинг бүхлээр нь засварлан шинэчилж, халаалтын системтэй болгон 2-3 айлын орон сууц болгох боломжийг судалж, хэрэгжүүлнэ.

1.7. Нөхөн сэргээх, уламжлалт эмчилгээний тусгай тасагтай болох асуудлыг холбогдох газар уламжлан шийдвэрлүүлнэ.

Хоёр. Боловсрол

2.1. Сумын хэмжээний цэцэрлэгийн насны хүүхэд бүрийг СӨБ-д хамруулах, хамрагдах боломжгүй хүүхдүүдийг хувилбарт сургалт буюу гэр цэцэрлэгт хамруулах ажлыг зохион байгуулна.

2.2. Цэцэрлэг, сургуулийн орчныг бүрэн камержуулж, аюулгүй суралцах боломжийг бүрдүүлнэ.

2.3. Өдөр өнжүүлэх анги бий болгож, ажиллуулах мэргэжлийн багш /хувь хүн/, аж ахуйн нэгжийг дэмжиж ажиллана.

Гурав. Соёл урлаг, Спорт, Аялал жуулчлал

3.1. Сумын номын сангийн сан хөмрөгийг нэмэгдүүлж, цахимжуулж дуусгана.

3.2. Орон нутгийн судлах танхимын халаалтын системийг засварлаж, үзмэр, сан хөмрөгөөр баяжуулж үйлчилгээ, сурталчилгааг олны хүртээл болгон чанарыг дээшлүүлнэ.

3.3. Үндэсний өв соёлоо хадгалах, түгээн дэлгэрүүлэх ажлын хүрээнд “Морин хуурч сургууль” хөтөлбөрийг хэрэгжүүлж ажиллана.

3.4. Байгалийн сайханд тулгуурлан Монголын түүх, шашин соёлын өв болон “Амар баясгалант” хийдийг түшиглэсэн аялал жуулчлалыг хөгжүүлэхэд анхаарч энэ бүс нутаг дахь хоршоо, иргэд, аж ахуйн нэгжийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл, борлуулалтыг дэмжиж ажиллана.

3.5. Аялал жуулчлалын бүс дэх отоглох цэгүүдэд ариун цэврийн эко ОО-тэй болно.

3.6. Орон нутгийн брэнд бүтээгдэхүүн үйлчилгээний төрөл (Нүүдэлчний) морь, тэмээ унуулах, үхэр болон морин тэргээр ойрын зайн аялал хийх зэрэг үйлчилгээг хөгжүүлэн, айл өрхийн орлогыг нэмэгдүүлэхэд анхаарч ажиллана.

3.7. Буудал, цайны газар, гэр буудал зэрэг үйлчилгээний газруудыг тодорхой стандарт шалгуурт нийцүүлэн, үйлчилгээг сайжруулахад анхаарч ажиллана.

3.8. Амарбаясгалант хийдэд орон нутаг, байгаль, түүх, соёлын, шашны үйл ажиллагааны талаар танилцуулдаг тусгайлсан хөтөч, тайлбарлагчтай болгох асуудлыг судалж, шийдвэрлэнэ.

3.9. Соёлын төвийг мэргэжлийн боловсон хүчнээр хангах, бүрэн орон тоогоор ажиллуулах, ажилтнуудыг давтан сургаж ур чадварыг нь дээшлүүлэх ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.

3.10. Хөгжим аппаратур, техник тоног төхөөрөмж, урлагийн хувцас хэрэглэлээр бүрэн хангана.

3.11. Соёлын биет бус өв, язгуур урлагийн шавь сургалтыг бий болгоход дэмжиж ажиллана.

3.12. Идэвхтэй хөдөлгөөн, нийтийн биеийн тамираар хичээллэх сонирхлыг дэмжиж, спорт ордны дэргэд сонирхлын клубүүдийг бий болгож, тусгай хуваарийн дагуу тогтмол хичээллэх ажлыг зохион байгуулна.

3.13. Сумын хэмжээнд Шагай, Хавчаахай харваа, Сурын харвааг хөгжүүлэхэд дэмжиж ажиллана.

3.14. Спорт ордоныг мэргэжлийн дасгалжуулагч багшаар ханган, ур чадварыг нь дээшлүүлэх, ажилтнуудын мэргэжлийн ёс зүй, харьцаа хандлага, ажлын хариуцлагыг дээшлүүлэхэд анхаарч ажиллана.

3.15. Спорт ордны барилгын засвар үйлчилгээнд жил бүр тодорхой хөрөнгө тусгах, тоног төхөөрөмж, хэрэглэгдэхүүнээр бүрэн хангаж, хүүхэд залуучууд иргэдийн ая тухтай хичээллэх боломжийг бүрдүүлнэ.

Дөрөв. Хөдөө Аж Ахуй

4.1. Газар тариалангийн аж ахуйн нэгжийн ашиглаж байгаа эргэлтийн талбай хөрсийг хамгаалах, сайжруулах, урсгал шимийг нэмэгдүүлэх талаар газар эзэмшигчийн хүлээх үүрэг хариуцлагыг дээшлүүлэхэд хяналт тавьж ажиллана.

4.2. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн хүлэмжийн аж ахуйг бүрэн зориулалтаар нь ажиллуулж, иргэд, айл өрх, байгууллагын хэрэгцээнд бүтээгдэхүүнээ жилийн турш тогтвортой нийлүүлдэг болгоход анхаарч ажиллана.

4.3. Тариалангийн талбайг хашаажуулах ажлыг үргэлжлүүлнэ.

4.4. Бэлчээрийн болон хагас эрчимжсэн аж ахуйг хослуулан хөгжүүлэх, зах зээлд ойр давуу талаа ашиглан эрчимжсэн мах, сүүний үхрийн аж ахуйг хөгжүүлэхэд бодлогоор дэмжиж ажиллана.

- 4.5. Бэлчээрийн төлбөрийн зарцуулалтыг ил тод болгон, үр дүнг тайлагнадаг байх, малчдын саналыг үндэслэн зориулалтын дагуу зарцуулдаг үйл явцыг сайжруулна.
- 4.6. Малчдад өвөлжөөний газраа урт хугацаатай эзэмших, ашиглах, тэжээлийн ургамал тариалахад бодлогоор дэмжиж ажиллана.
- 4.7. Бэлчээрийг усжуулах, худагтай болгох ажлыг үргэлжлүүлнэ.
- 4.8. Малын арьс шир, мах, сүүгээр бүтээгдэхүүн үйлдвэрлэх жижиг цех үйлдвэрлэл бий болгоход хоршоо, иргэдийг бодлогоор дэмжих, хөдөлмөр эрхлэлтийн зээл тусламжид хамруулна.
- 4.9. Сумын хэмжээнд бэлчээрийн даацтай уялдуулан малын тоо толгой, төрөл, бүтцийн байдалд дүн шинжилгээ хийж, малаа чанаржуулах, эрчимжүүлэх чиглэлээр ажиллаж буй малчдыг төсөл хөтөлбөр, зээлээр дэмжих бодлого баримтална.

Тав.Байгаль орчин

- 5.1. Сумын нутаг дэвсгэр дэх хашаа хамгаалалгүй булаг шандын эхийг хашаажуулан хамгаална.
- 5.2. Ойн мэргэжлийн байгууллагуудын менежмент төлөвлөгөөнд тусгагдсан гол усны эхээс мод бэлтгэх газруудыг хянан үзэж, гол усанд сөрөг нөлөөлөл үзүүлэхүйц тохиолдолд өөрчлөх, шаардлагатай гэж үзвэл хориглох хүртэл арга хэмжээ авна.
- 5.3. Ойн мэргэжлийн байгууллагуудын мод бэлтгэлийн үйл ажиллагааны хяналтыг сайжруулж, зөрчил гарсан тохиолдолд гэрээг цуцлах, улмаар бодлогоор багасгах арга хэмжээ авна.
- 5.4. Иргэд, малчдын өвөлжөө, хашааг сэлбэх зориулалтын модыг хэрэгцээнд үндэслэн тооцоолж, холбогдох газарт уламжлан, хуваарьт тусгайлан оруулж байх арга хэмжээг авна.
- 5.5. Хууль бус ан агнуур, модны хулгайг таслан зогсоох арга хэмжээ авна.
- 5.6. Сумын хэмжээний нутаг дэвсгэр дэх хог хаягдлыг цэвэрлэх, булж дарах, зам дагуу үүссэн хог хаягдлын цэгийг дарж, нөхөн сэргээх арга хэмжээ авна.

Зургаа.Сумын төвийн шинэчлэл хөгжил

- 6.1. Гудамж талбайн гэрэлтүүлгийн өргөтгөл хийнэ.
- 6.2. Сумын төвдөө явган хүний замтай болж, хашаа хоорондын өнгө үзэмжийг сайжруулах, үзэмж муутай зарим хашааг буулгах арга хэмжээ авч ажиллана.
- 6.3. Сумын төвд цэвэрлэх байгууламжтай болох, цэвэр бохирын шугамыг шинэчлэн засварлаж, төсөвт байгууллагуудын бохирын байгууламжуудыг нэгдсэн цэвэрлэх байгууламжид холбоно.
- 6.4. Боловсон нойлтой болж нүхэн жорлонгуудыг хална.
- 6.5. Зам дагуу автобусны зогсоолыг шинэчилнэ.
- 6.6. Усан сангийн хамгаалалтын бүсийг засварлан шинэчилнэ.
- 6.7. Ус хангамжийн уст цэгүүдийн барилга байгууламжийг засварлан шинэчлэх, ус цэвэршүүлэх төхөөрөмж тавьж, эрүүл ахуйн шаардлага хангасан усаар хангана.


Долоо.Хариуцлагатай шударга засаглал

- 7.1. ИТХ болон төрийн аливаа шийдвэр гаргалтад хүний эрхийн мэдрэмжтэй хандаж, төрийн хүнд суртлыг арилгана.
- 7.2. Төрийн үйл ажиллагаа, төсвийн зарцуулалтад иргэн, хөндлөнгийн хяналтыг ил тод, нээлттэй байлгана.

7.3. Төрийн албаны үйл ажиллагаа, ёс зүй хандлагыг дээшлүүлж, ажил дүгнэх гэрээний нэг заалт болгон үнэлж, соёлтой үйлчилгээг хэвшүүлнэ.

7.4. Төрийн байгууллагын үйл ажиллагаа, үйлчилгээний талаар цахим хэлэлцүүлэг хийж, иргэд санал бодлоо илэрхийлдэг боломж бий болгоно.

7.5. Хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөрөөр хэрэгжиж буй ажил, арга хэмжээнд дотоод аудит хийж, үр дүнг олон нийтэд нээлттэй мэдээлнэ.



**СЭЛЭНГЭ АЙМГИЙН БАРУУНБҮРЭН СУМЫН
МАН-ЫН ХОРОО**